



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2023/199/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.selenge@audit.gov.mn](http://www.selenge@audit.gov.mn)

Сүхбаатар сум  
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Аудитор: Л.Дамдинжав

Утас: 70376994 Цахим хаяг: [dalaivandarkhan@gmail.com](mailto:dalaivandarkhan@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БШУГ	Боловсрол шинжлэх ухааны газар
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
ЗГ	Засгийн газар
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ОУБ	Олон улсын байгууллага

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
3.Санхүүгийн тайлангийн тодруулга .....	13
3.1.Байгууллага түүний үйл ажиллагаа.....	13
3.2. Байгууллагын гадаад дотоод орчин .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..	15
3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	16
4.Аудитын тайлан .....	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
5. Аудитын илрүүлэлт .....	20
5.1 Акт .....	20
5.2 Зөвлөмж.....	20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	21



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ХҮДЭР СУМЫН 1 ДҮГЭЭР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
В.ЦЭРЭНСҮРЭН ТАНАА

2023.02.25 № ЦА-2023/199-НА-СА-ТМЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүдэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Хүдэр сумын 1 дүгээр цэцэрлэг нь үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 96.2 хувьтай тайлагнагдсан байна.

Цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 8,925.8 мянган төгрөгөөр, хоолыг зардлыг 9,405.5 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний зардал 1,308.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалж, нийт батлагдсан төсөв 3.8 хувиар хэмнэгдсэн байна.

018020265

## **Аудитын гол асуудал**

Хүдэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 75.8 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, 8.5 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал эзэлж байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>40,265,716.00</b>	<b>72,078,792.10</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>0.00</b>	<b>20,624,044.10</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>0.00</b>	<b>20,624,044.10</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>0.00</b>	<b>20,624,044.10</b>
31211	Төрийн сангийн харилцах	0.00	20,624,044.10
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>40,265,716.00</b>	<b>51,454,748.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>40,265,716.00</b>	<b>51,454,748.00</b>
35410	Бичиг хэргийн материал	456,000.00	456,000.00
35420	Аж ахуйн материал	24,855,176.00	35,575,604.00
35460	Хүнсний материал	1,250,290.00	1,718,894.00
35470	Бусад хангамжийн материал	13,704,250.00	13,704,250.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,096,613,535.69</b>	<b>1,227,800,727.96</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,096,613,535.69</b>	<b>1,227,800,727.96</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,086,539,535.69</b>	<b>1,217,726,727.96</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,136,203,498.19	1,300,331,468.19
39202	Хуримтлагдсан элэгдэл	-105,637,837.17	-138,393,797.61
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	43,797,804.00	52,577,804.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-20,336,235.64	-31,048,252.87
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55,225,738.50	63,410,738.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-28,723,611.73	-34,365,630.47
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,957,813.50	7,957,813.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,387,343.96	-3,183,125.28
39217	Ном	439,710.00	439,710.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>10,074,000.00</b>	<b>10,074,000.00</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	10,074,000.00	10,074,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,136,879,251.69</b>	<b>1,299,879,520.06</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>42</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>42200</b>	<b>Урт хугацаат зээл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,136,879,251.69</b>	<b>1,299,879,520.06</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,136,879,251.69</b>	<b>1,299,879,520.06</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	0.00	85,202,272.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	0.00	85,202,272.00
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	<b>85,202,272.00</b>	0.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>261,080,954.81</b>	<b>424,081,223.18</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	278,971,664.71	-875,798,296.88
51220	Тайлант үеийн үр дүн	-17,890,709.90	1,299,879,520.06
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	790,596,024.88	790,596,024.88
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,136,879,251.69</b>	<b>1,299,879,520.06</b>

## 2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ТӨГРӨГӨӨР /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>450,560,133.00</b>	<b>1,855,295,923.77</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>17,752,300.00</b>	<b>1,310,660,721.69</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>17,752,300.00</b>	<b>1,310,660,721.69</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	13,972,000.00	1,268,991,505.69
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	3,780,300.00	41,669,216.00
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	0.00	0.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>432,807,833.00</b>	<b>544,635,202.08</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>393,680,100.00</b>	<b>474,915,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	474,915,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	393,680,100.00	0.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>243,000.00</b>	<b>6,000,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	6,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	243,000.00	0.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>38,849,733.00</b>	<b>63,719,802.08</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,849,733.00	63,719,802.08
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>468,450,842.90</b>	<b>555,416,403.71</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>468,450,842.90</b>	<b>555,416,403.71</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>423,594,095.90</b>	<b>555,416,403.71</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>282,463,282.00</b>	<b>352,714,407.90</b>
210101	Үндсэн цалин	211,327,039.00	264,179,705.90
210102	Нэмэгдэл	49,855,395.00	83,735,206.00
210104	Урамшуулал	21,280,848.00	4,799,496.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>36,896,505.00</b>	<b>44,729,227.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	25,603,772.47	30,693,774.85
210202	Тэтгэмжийн даатгал	2,893,549.42	3,508,887.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,254,504.24	2,774,641.98
210204	Ажилгүйдлийн даатгал	546,828.95	734,245.52
210205	Эрүүл мэндийн даатгал	5,597,849.92	7,017,677.15
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>38,326,833.00</b>	<b>44,767,175.08</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,298,933.00	6,730,375.08
210302	Түлш, халаалт	29,877,100.00	32,886,000.00
210303	Цэвэр, бохир ус	5,150,800.00	5,150,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,690,949.00</b>	<b>60,000.00</b>
210401	Бичиг хэрэг	173,900.00	0.00

**Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210402	Тээвэр, шатахуун	514,500.00	60,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	412,500.00	0.00
210404	Ном, хэвлэл	126,500.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,014,500.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,449,049.00	0.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>12,428,976.00</b>	<b>49,127,536.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	110,900.00	0.00
210502	Хоол, хүнс	12,318,076.00	49,127,536.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,368,700.00</b>	<b>461,000.00</b>
210604	Урсгал засвар	1,368,700.00	461,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>177,700.00</b>	<b>0.00</b>
210702	Дотоод албан томилолт	177,700.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,265,900.00</b>	<b>540,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	668,700.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	597,200.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	540,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>46,975,250.90</b>	<b>63,017,057.73</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,975,250.90	7,599,090.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,556,000.00	5,512,190.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,419,250.90	49,905,777.73
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>44,856,747.00</b>	<b>0.00</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>44,856,747.00</b>	<b>0.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-17,890,709.90</b>	<b>1,299,879,520.06</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-</b>	<b>1,299,879,520.06</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>432,807,833.00</b>	<b>544,635,202.08</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>432,807,833.00</b>	<b>544,635,202.08</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>393,680,100.00</b>	<b>474,915,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	35,000.00	474,915,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	393,680,100.00	0.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>243,000.00</b>	<b>6,000,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	6,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	243,000.00	0.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>38,849,733.00</b>	<b>63,719,802.08</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,849,733.00	63,719,802.08
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	35,000.00	0.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>429,807,833.00</b>	<b>515,296,157.98</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>429,807,833.00</b>	<b>515,296,157.98</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>384,951,086.00</b>	<b>515,296,157.98</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>282,463,282.00</b>	<b>352,714,407.90</b>
210101	Үндсэн цалин	211,327,039.00	264,179,705.90
210102	Нэмэгдэл	49,855,395.00	83,735,206.00
210104	Урамшуулал	21,280,848.00	4,799,496.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>36,896,505.00</b>	<b>44,729,227.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	25,603,772.47	30,693,774.85
210202	Тэтгэмжийн даатгал	2,893,549.42	3,508,887.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,254,504.24	2,807,050.06
210204	Ажилгүйдлийн даатгал	546,828.95	701,837.44
210205	Эрүүл мэндийн даатгал	5,597,849.92	7,017,677.15
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>38,326,833.00</b>	<b>44,767,175.08</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,298,933.00	6,730,375.08
210302	Түлш, халаалт	29,877,100.00	32,886,000.00
210303	Цэвэр, бохир ус	5,150,800.00	5,150,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,580,000.00</b>	<b>0.00</b>
210401	Бичиг хэрэг	173,900.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	514,500.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	412,500.00	0.00
210404	Ном, хэвлэл	126,500.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,014,500.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	338,100.00	0.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>18,846,166.00</b>	<b>55,033,568.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	110,900.00	0.00
210502	Хоол, хүнс	13,568,366.00	49,596,140.00

**Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210503	Нормын хувцас, зөөлөн адлэл	5,166,900.00	5,437,428.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,838,700.00</b>	<b>461,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	470,000.00	0.00
210604	Урсгал засвар	1,368,700.00	461,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>177,700.00</b>	<b>0.00</b>
210702	Дотоод албан томиллолт	177,700.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,265,900.00</b>	<b>540,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	668,700.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	597,200.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	540,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,556,000.00</b>	<b>17,050,780.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,556,000.00	11,642,090.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	5,408,690.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>44,856,747.00</b>	<b>0.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>44,856,747.00</b>	<b>0.00</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>3,000,000.00</b>	<b>29,339,044.10</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>3,000,000.00</b>	<b>8,715,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,000,000.00</b>	<b>8,715,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>3,000,000.00</b>	<b>8,715,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,000,000.00	8,715,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-3,000,000.00</b>	<b>-8,715,000.00</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>0.00</b>	<b>20,624,044.10</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	20,624,044.10

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	85,202,272.00	790,596,024.88	261,080,954.81	1,136,879,251.69
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
4	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
5	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00
6	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
7	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	85,202,272.00	790,596,024.88	261,080,954.81	1,136,879,251.69
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-1,136,879,251.69	-1,136,879,251.69
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
10	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
11	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
12	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,299,879,520.06	1,299,879,520.06
13	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	85,202,272.00	790,596,024.88	424,081,223.18	1,299,879,520.06

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү дүн	Харьцуулалт
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>538,635,202.08</b>	<b>524,011,157.98</b>	<b>14,624,044.10</b>	<b>97.28</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>538,635,202.08</b>	<b>524,011,157.98</b>	<b>14,624,044.10</b>	<b>97.28</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>538,635,202.08</b>	<b>524,011,157.98</b>	<b>14,624,044.10</b>	<b>97.28</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>361,224,161.00</b>	<b>352,714,407.90</b>	<b>8,509,753.10</b>	<b>97.64</b>
210101	Үндсэн цалин	305,840,553.00	264,179,705.90	41,660,847.10	86.38
210102	Нэмэгдэл	51,629,208.00	83,735,206.00	-32,105,998.00	162.19
210104	Урамшуулал	3,754,400.00	4,799,496.00	-1,045,096.00	127.84
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>45,145,266.00</b>	<b>44,729,227.00</b>	<b>416,039.00</b>	<b>99.08</b>
210201	Тэтгэврийн даатгал	30,866,725.16	30,693,774.85	172,950.31	99.44
210202	Тэтгэмжийн даатгал	3,569,685.21	3,508,887.50	60,797.71	98.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,823,280.09	2,807,050.06	16,230.03	99.43
210204	Ажилгүйдлийн даатгал	746,405.12	701,837.44	44,567.68	94.03
210205	Эрүүл мэндийн даатгал	7,139,170.42	7,017,677.15	121,493.27	98.30
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>44,767,175.08</b>	<b>44,767,175.08</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,730,375.08	6,730,375.08	0.00	100.00
210302	Түлш, халаалт	32,886,000.00	32,886,000.00	0.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	5,150,800.00	5,150,800.00	0.00	100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>		
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>59,001,600.00</b>	<b>55,033,568.00</b>	<b>3,968,032.00</b>	<b>93.27</b>
210502	Хоол, хүнс	59,001,600.00	49,596,140.00	9,405,460.00	84.06
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,000,000.00	5,437,428.00	562,572.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>461,000.00</b>	<b>461,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210604	Урсгал засвар	461,000.00	461,000.00	0.00	100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>962,000.00</b>	<b>540,000.00</b>	<b>422,000.00</b>	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	962,000.00	540,000.00	422,000.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>27,074,000.00</b>	<b>25,765,780.00</b>	<b>1,308,220.00</b>	<b>95.17</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,774,000.00	20,357,090.00	416,910.00	97.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,300,000.00	5,408,690.00	891,310.00	85.85
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	

<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>544,635,202.08</b>	<b>544,635,202.08</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>131</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>474,915,400.00</b>	<b>474,915,400.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	474,915,400.00	474,915,400.00	0.00	100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,000,000.00	6,000,000.00	0.00	
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>63,719,802.08</b>	<b>63,719,802.08</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
320001	Орон нутгийн төсвөөс	63,719,802.08	63,719,802.08	0.00	100.00
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	0.00	0.00	0.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	20,624,044.10	-20,624,044.10	
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүдэр сумын 1 дүгээр цэцэрлэг нь “Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлд туслах, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж бүх талуудын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хамтран ажиллая” гэсэн зорилт тавин ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Танхимын сургалтын хүүхэд бүрийг сурч хөгжих, төлөвших эрүүл аюулгүй нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хүүхдийн сурлага, хүмүүжил, хөгжил, хамгааллын асуудлаар эцэг эх, асран хамгаалагчидтай хамтран ажиллах гэрээ байгуулж, эргэх холбоотой ажиллах,
- Гэнэтийн болон давтагдашгүй хүчин зүйлд сургалтыг тасралтгүй үргэлжлүүлж бэлэн байдлыг хангаж цахим сан бүрдүүлж ашиглах,
- Сумын тойргийн сургуульд бэлтгэх 5 настай хүүхдүүдийг цэцэрлэгт бүрэн хамруулж, сургуульд бэлтгэн суралцуулах,
- Арга зүйн нэгдлээр сургалтын арга хэлбэрийг оновчтой сонгон, заах арга зүйгээ хөгжүүлж хамтран ажиллах,
- “Сургалтын байгууллага- тоног төхөөрөмж” арга хэмжээний хүрээнд цэцэрлэгт шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлэн эрүүл аюулгүй ээлтэй орчин бүрдүүлэх
- “Тогтвортой хөгжлийг дэмжигч эко цэцэрлэгийн орчин” хөтөлбөрийн хүрээнд байгууллагын гадна, дотор орчинд тохижилт үйлчилгээг сайжруулж эрүүл аюулгүй таатай, дулаан орчинг бүрдүүлж сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах
- Цэцэрлэгт хэрэглэгдэх хүнсний бүтээгдэхүүний чанарт тавих хөндлөнгийн хяналтыг сайжруулж, эрүүл хүнсээр хангах
- Багш, удирдах ажилтны ёс зүйг сахиулах үр дүнг тооцож, байгууллагын үйл ажиллагааг эцэг эх, багш ажилчдын оролцоотой үнэлэх,

#### 3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- Боловсролын тухай хуульд 2022 онд 3 удаа нэмэлт өөрчлөлт орсон,

- ЗГ-ын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” журам хэрэгжиж эхэлсэн,
- ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоолын 5, 6 дугаар хавсралтаар батлагдсан “Шинжлэх ухааны байгууллага, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ батлах тухай ” тогтоолд 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох” тогтоолд 2022 оны 252 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- БШУС-ын 2022 оны А/170 дугаар тушаалаар батлагдсан “Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг хэрэгжүүлж эхэлсэн,
- БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуульд, кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам”-ыг шинэчлэн баталсан,
- ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” хэрэгжиж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагч болох БШУЯ-ны зүгээс дотоод аудит, хяналт, шалгалт хийгдээгүй бөгөөд дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүдэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь өмнөх онуудад тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсны хувьд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/202 тоот захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн харьяа төсөвт байгууллагууд

дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тайлант онд мөрдөж ирсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

### 3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүдэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 163,000.2 мянган төгрөгөөр буюу 12.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		20,624.04	20,624.00
Авлага		0.00	0.00
Бараа материал	40,265.72	51,454.75	11,189.00
Үндсэн хөрөнгө	1,096,613.54	1,227,800.73	131,187.19
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,136,879.26</b>	<b>1,299,879.52</b>	<b>163,000.26</b>
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,136,879.26	1,299,879.52	163,000.26
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,136,879.26</b>	<b>1,299,879.52</b>	<b>163,000.26</b>

Тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 20,624.0 мянган төгрөгийг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын 8.7-д “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 11,189.0 мянган төгрөгөөр өссөн нь сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 1,403.5 мянган төгрөгийн хулдаас, гутлын тавиурыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 67,876.8 мянган төгрөгийн бараа материал бэлтгэн, 58,091.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэлд /анхны өртгөөр/ 181,092.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 164,127.9 мянган төгрөгийн барилгын их засвар, эцэг эх, ААН-н хандиваар 8,250.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 8,715.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,299,879.5 мянган төгрөг болж 163,000.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 725,044.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 69,474.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг **794,518.8** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс НДШ-ийн зардлыг 191,163.3 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 50,566.7 мянган төгрөгөөр, бусад зардлыг 8,153.6 мянган төгрөгөөр тус тус бууруулж, улсын төсвөөс 464,915.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 63,719.8 мянган төгрөг, туслах үйл ажиллагаанаас 16,000.0 мянган төгрөг нийт **544,635.2** мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр **544,635.2** мянган төгрөгийн төсөв баталснаас 464,915.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 63,719.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, туслах үйл ажиллагаанаас 16,000.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд захиран зарцуулахаар төлөвлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **524,011.2** мянган төгрөг буюу 96.2 хувьтай тайлагнагдсан нь цалин, НДШ-ийн зардал 8,925.8 мянган төгрөгөөр, хоолны зардал 9,405.5 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 1,308.2 мянган төгрөгөөр, мэдээлэл технологийн зардал 422.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр	Д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71801 Сургуулийн өмнөх боловсрол	1	81605-Эрүүл мэндийг дэмжих	1,300.00	1,300.00	-	100.00
		2	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	59,001.60	49,596.10	9,405.50	84.06
		3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,138.00	2,000.00	138.00	93.55
		4	81823-Боловсролын	1,300.00	1,050.00	250.00	80.77

	байгууллагын багш				
5	81834-Боловсролын стандарт сургалт	361,246.10	356,118.70	5,127.40	98.58
6	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	39,929.70	34,789.10	5,140.60	87.13
7	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	63,719.80	63,719.80	-	100.00
	Туслах үйл ажиллагаа	10,000.00	10,000.00	-	100.00
8	80112-Нийтлэг үйлчилгээ	6,000.00	5,437.50	562.50	90.63
<b>Нийт</b>		<b>544,635.20</b>	<b>524,011.20</b>	<b>20,624.00</b>	<b>96.21</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус цэцэрлэгийн нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хүдэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн илүү олгосон цалинг залруулга хийж, зөв дүнгээр бүртгэхтэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Л.Дамдинжав, аудиторын туслах Б.Сувд-Эрдэнэ нар гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүдэр сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## **4.2. Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 468,520.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,685.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Боловсролын ерөнхий газраас нийт боловсролын байгууллагуудад 2022 оны 04, 09 дүгээр саруудад Төрийн хэмнэлтийн тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, төрийн үйл ажиллагааг цахимжуулах, бараа үйлчилгээний зардлыг бууруулах, зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Хүдэр сумын 1 дүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Тайлант онд хоолны зардал, бараа үйлчилгээний бусад зардал, цалин, ажил олгогчоос төлөх НДШ-н зардлаас нийт 20,624.0 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгосон байна.

## **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Хүдэр сумын 1 дүгээр цэцэрлэг нь мэдээлбэл зохих 20 төрлийн 151 мэдээллээс 16 мэдээг хугацаа хоцроож, 8 мэдээг огт мэдээлээгүй байна.

- Төсөв гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг 5 удаа хугацаа хоцроож, 5 удаа огт мэдээлээгүй,
- Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой мэдээллийг 8 удаа хугацаа хоцроосон

- Бусад мэдээллийг 3 удаа хугацаа хоцроож, 3 удаа огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

“Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын 2022 оны 11 дүгээр 09-ны өдрийн 41 дүгээр албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус сургуулийн 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тушаал шийдвэргүйгээр 122.2 мянган төгрөгийн цалин илүү олгосон зөрчил илэрч зөрчлийг арилгах төлбөрийн акт, төлбөрийн цахим баримттай холбоотой 13,568.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	122.2	1	122.2	100.00
Албан шаардлага					
Зөвлөмж	2	13,568.4	2	13,568.4	100.00
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>13,690.6</b>	<b>2</b>	<b>13,690.6</b>	<b>100.00</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлууд нь тухайн төсвийн захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн учир дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан, хяналт тавьж байх шаардлагатай байна.
2. Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан “Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан” гэсэн зориулалтаар, төсөвт байгууллагын өөрийн

үйл ажиллагааны орлого /120010/ ангиллаар гүйцэтгэхээр чиглэл хүргүүлсэн байна. Нэмэлтээр хуваарилах төсвийн эх үүсвэрийг төсвийн санхүүжилтийн эх үүсвэр болгон төлөвлөж байгаагаас гүйцэтгэлээр уг санхүүжилт хуваарилагдаагүй тохиолдолд төсвийн санхүүжилтийн төлөвлөгөө тасарснаар тайлагнагдах эрсдэлтэй байна. Иймд дээд шатны төсвөөс хуваарилах нэмэлт төсвийг төсвийн санхүүжилт хэлбэрээр урьдчилан төлөвлөж, батлалгүйгээр санхүүжилт ирсэн тухай бүр тухайн санхүүжилтийн дүнгээр зарцуулах эрх тавих нь зүйтэй юм.

3. Тус байгууллага нь өмнөх жилүүдэд тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсан учир Сэлэнгэ аймгийн ЗД-ын 2020 оны 7 дугаар сарын 16-ний өдрийн А/202 дугаар захирамжаар баталсан “Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж ирсэн байна. Бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч боловсролын байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй учир төсвийн ерөнхийлөн захирагчийн боловсруулсан НБББББ-ыг мөрдөх нь зүйтэй юм.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **3,799.2** мянган төгрөгийн зөрчил илэрч 1,243.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,555.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

1. Төлбөр, тооцоог урьдчилан хянаагүйн улмаас нэмэгдэл цалинг 1,243.5 мянган төгрөгөөр илүү тооцож, олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- Ээлжийн амралтын цалинг илүү тооцож багш Ц.Сэлэнгэд 700.7 мянган төгрөг,
- Ажилласан цагийн хөлсийг зөрүүтэй тооцож, багш Д.Отгондуламд 542.8 мянган төгрөг.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

### 5.2 Зөвлөмж

1.1. Илрүүлэлт: Нийгмийн даатгалын тайланд багш нарын амралтын цалинг 2,555.7 мянган төгрөгөөр илүү тооцож тайлагнасан нь “Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д *“хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Илүү тайлагнасан цалинг 2023 оны 1 дүгээр улиралд залруулга хийж зөв дүнгээр тайлагнах

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин илүү олгосон.	1	1,243.5	1	1,243.5								
НДШ илүү тайлагнасан	1	2,555.7					1	2,555.7				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>3,799.2</b>	<b>1</b>	<b>1,243.5</b>			<b>1</b>	<b>2,555.7</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон	16						16	
Огт мэдээлээгүй	8						8	
<b>Дүн</b>	<b>24</b>						<b>24</b>	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>								